

ДеФакто **ТОЙМ**

НИЙТЛЭЛ

ДеФакто **НИЙТЛЭЛ**

ҮНИЙН ХӨӨРӨГДӨЛ
7.2% БАЙНА

БОЛОВСРОЛ ЯМАР
ҮНЭТЭЙ ВЭ?

ВЕЙСЭЛ АКЧАЙН ХЭРЭГ
ЮУ БОЛЖ БАЙНА ВЭ?

VI НҮҮРТ

Б.ГЭРЭЛМАА

АНУ-д төвтэй STEPPE TECH компанийн
гүйцэтгэх захирал.

САНХҮҮГИЙН ШИНЭ ТЕХНОЛОГИЙГ

АЮУЛГҮЙ
НЭВТРҮҮЛЭХ
БОЛОМЖ

IV НҮҮРТ

Буянт-Ухаагийн

БУМАН
БОЛОМЖ II

II НҮҮРТ

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

ЗОРИГЖУУЛНА

МЭДЭЛЖҮҮЛНЭ

Лхагва, 2018.08.08, №58

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН ДОЛОО ХОНОГ ТУТМЫН СОНИН

www.defacto.mn





№ 442

Дамбадаржаагийн **ЖАРГАЛСАЙХАН**Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>**Буянт-Ухаагийн****БУМАН БОЛОМЖ II**

Хөшигийн хөндийн шинэ онгоцны буудал ашиглалтанд орох гэж буй нь Буянт-Ухаа дахь онгоцны буудалд ямар их боломж нээгдэж байгааг өнгөрсөн долоо хоногт **“Буянт Ухаагийн буман боломж”** нийтлэлдээ агаарын хөлгийн техникийн үйлчилгээний бизнесийн жишээн дээр өгүүлсэн. Энэ удаа бусад боломжоос онцолж байна.

Гурван жилийн өмнө Ази-Европын дээд хэмжээний (АСЕМ) уулзалтыг угтан “Чингис хаан” олон улсын нисэх буудалд 20 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж транзит танхим, агаарын хөлгийн 9 зогсоол байгуулж, талбайг өргөтгөж, хөөрч, буух хучилттай зурвасын 500 метрийг нь хүчитгэсэн.

“*Буянт-Ухаагийн онгоцны буудлын өнөөгийн үнэ цэнэ бараг 300 сая ам.доллар буюу 750 тэрбум төгрөг. Энэ буудалд оруулсан энэ их хөрөнгийнхөө өгөөжийг гаргах ёстой.*”

Буянт-Ухаа дахь нисэх буудлын барилга,

байгууламжид иргэний нисэхийн тодорхой үйлчилгээнүүдээ авч үлдэн, хөгжлийн шинэ хэрэгцээг угтуулан үйлчлэх боломжтой юм. Харин ямар үйлчилгээ бий болгохоо яаралтай шийдэхгүй бол 480 га талбайг харж хамгаалах, барилга, байгууламжийг дулаан, цахилгаан, цэвэр бохир усаар хангах зардал нь жил бүр тэнгэрээс (навигацийн орлого) бууж байгаа 100 сая ам.долларын улсын төсөвт татдаг хөрөнгөөс суутгаж таарна.

Буянт-Ухаа дахь нисэх буудлыг агаарын хөлгийн техник үйлчилгээ засвараас гадна ерөнхий зориулалтын нисэхийн хэрэгцээг хангах, нисэхийн сургууль байгуулах, бага оврын жижиг онгоц угсрах зэргээр ашиглаж болно. Энэ бүгдийг алсын хараатай түргэн шуурхай зохион байгуулж, эхлээд төрийн, дараа нь олон нийтийн эзэмшлийн хувьцаат компани болгон хөгжүүлвэл тэнгэрээс буух “бороо” улам ихсэх болно.

ЕРӨНХИЙ ЗОРИУЛАЛТЫН НИСЛЭГИЙН БОЛОМЖ

Иргэний агаарын тээврийг зорчигч, ачаа тээврийн арилжааны хуваарьт нислэг ба ерөнхий зориулалтын нислэг гэж хоёр ангилдаг. Монгол улсын хувьд зорчигч, ачаа тээврийн арилжааны хуваарьт нислэг Хөшигийн хөндийд, ерөнхий зориулалтын нислэг Буянт-Ухаад төвлөрөх боломж байна.

Манай улсад ерөнхий зориулалтын буюу бага оврын агаарын хөлөг, нисдэг тэргээр агаарын такси, хөдөө аж ахуйн, барилгын, зураг авалтын, тандалт хайгуулын, цаг уурын, эргүүл ажиглалтын, эмнэлгийн, эрэн хайх, авран туслах болон агаарын сурталчилгааны, нисэхийн спортын, сургалт дадлагын, сонирхогчийн зэрэг нислэг хийх эрэлт хэрэгцээ сүүлийн жилүүдэд улам өссөөр байна.

2017 онд уул уурхайн захиалгат нислэгээр Оюутолгой, Овоотын чиглэлд 216 мянган зорчигч тээвэрлэсэн нь орон нутгийн хуваарьт нислэгийнхээс хоёр дахин их байжээ. Иргэдэд онцгой байдлын үед зайлшгүй хэрэгцээтэй эмнэлгийн яаралтай тусламж, хөдөө аж ахуй, байгаль орчныг хамгаалах зэрэг

нийгмийн шинжтэй нислэг хийх боломж бага байна. Монголын цэрэг, цагдаа хүчний байгууллагуудын шуурхай ажиллагаанд агаарын хөлөг, нисэх буудал мэдээж шаардлагатай.

Мөн хувийн, албан хэргийн, аялал жуулчлалын, эйр такси зэрэг орчин үеийн бизнесийн зориулалттай нислэгийн эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй байна.

Иргэд хувийн хэрэгцээндээ агаарын хөлөг ашиглах шаардлага их болж буйг тооцох цаг болжээ. Нийслэл хотод ойрхон, онгоцоо хадгалж, хөөргөж буулгаж болох хамгийн тохиромжтой аэродром бол Буянт-Ухаа. Хувь хүн өөрийн хэрэгцээнд авч ашиглах бага оврын агаарын хөлөг, нисдэг тэрэгт тавигдах стандарт, шаардлагыг яаралтай тогтоож, холбогдох зохицуулалтыг бүрдүүлэх, хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэх агаарын хөлгийн холбоо, нислэгийн удирдлагын (навигацийн) төхөөрөмжийг нэмж суурилуулах шаардлагатай байна.

НИСЭХИЙН СУРГАЛТЫН ТӨВ

“ Дэлхий дээр цэргийнхээс бусад агаарын хөлгийн тоо 2010 оны байдлаар 62 мянга байсан бол 2030 онд 152 мянгад хүрэх тооцоог Олон Улсын Иргэний Чисэхийн Байгууллага /ИКАО/ гаргажээ. ”

Энэ нь 26-52 сая цагийн нислэг үйлдэх нисгэгч, засвар үйлчилгээний ажилтан, нислэгийн удирдагч гэх мэт шинээр 2 сая мэргэжилтэн шаардлагатай. Жилээс жилд өсөн нэмэгдэж буй нисэхийн мэргэжилтнүүдийн эрэлт хэрэгцээг одоо байгаа сургалтын байгууллагуудын хүчин чадал хангаж чадахгүй байна.

Энэ их эрэлт хэрэгцээний 40 хувь нь Ази Номхон далайн бүс нутагт ногдоно. 2020 он гэхэд урд хөршийн ерөнхий зориулалтын агаарын хөлгийн тоо 5000 болж, 500 нисэх буудал баригдаж, 1.75 сая цагийн нислэг үйлдэх ажээ. Тэд бага оврын агаарын хөлгийн үйлдвэрлэлээ эрс нэмэгдүүлж байна.

Газар нутгийн байршлын давуу тал, жилийн гуравны хоёр нь цэлмэг байдаг, дөрвөн улиралтай учир нислэгийн бүх нөхцлийг бүрдүүлж чадах цаг агаарын онцлогоо ашиглаж юуны өмнө хоёр хөршийн нисэхийн мэргэжилтэн дадлага туршилт хийдэг сургалтын төвийг байгуулах боломж, хэрэгцээ, шаардлага байна.

Хятад улсад агаарын орон зайг нь Батлан хамгаалах яам нь хянаж иргэний нислэг бүрийн зөвшөөрлийг олгодог, сургалтын нислэг хийхэд төвөгтэй учир монголд нисэхийн сургууль байгуулах сонирхол урд

МОНГОЛД УГСРАВ

Бага оврын агаарын хөлгийн үйлдвэрлэл, засвар үйлчилгээний төв байгуулах, засвар үйлчилгээний сүлжээг бүрдүүлэх боломж манайд байна. Энэ талаар МИАТ компани Оросуудтай хамтран хуучин АН-2 онгоцыг монголд угсрах туршилт хийж байна. Новосибирск хотод энэ онгоцны шинэчилсэн ТВС-2МС загварыг бүтээжээ.

Энэ онгоц ус, цас, хөрсөнд хаана ч буудаг, 50 м гүйгээд хөөрдөг, 1400 км буухгүй нисдэг, 12 хүний

хөршид байгаа ажээ. Бас олон мянган залуу нисгэгч шинээр бэлтгэх шаардлагатай ч Англи, Америкийн виз авах нь хүндрэлтэй байдаг гэнэ ээ.

Манай улсад ч иргэний нисэхийн боловсон хүчний эрэлт хэрэгцээ нэмэгдэж дотооддоо бэлдэхээс гадна гадаадад бэлддэг.

“ Сүүлийн 6 жилд гэхэд ИЧЕГ-аас нисэхийн 56 мэргэжилтнийг АНУ, Канад, Украин, Тайланд, ОХУ, Австрали зэрэг улсуудад бэлдэхэд 1,7 сая ам.доллар зарцуулжээ. ”

Буянт-Ухаа дахь нисэхийн цогц дэд бүтцээ ашиглан олон улсын стандарт шаардлагыг хангасан, бүс нутгийн хэмжээнд сургалт зохион байгуулах хүчин чадал бүхий сургалтын төв байгуулж агаарын хөлгийн нисгэгч, инженер техникийн ажилтан бэлтгэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхлэх хэрэгтэй байна. Энэ сургуулийг олон улсын төслийн санхүүжилтээр, гадаадын шилдэг мэргэжилтнүүдийг ажиллуулах замаар эхлүүлж, өөрсдөө бүрэн төгс сурах ёстой. АНУ, Европын сургагч багш нарыг авчран, тэдний салбар сургуулийн хэлбэрээр ч эхлүүлж болох юм. Эхлээд дадлагын төв, яваандаа иж бүрэн нисэхийн сургууль болгож дэлхий даяар хүлээн зөвшөөрөх хүртэл хөгжих зорилго тавих хэрэгтэй.

Нисэхийн сургууль байгуулж чадвал Буянт-Ухаа дахь онгоцны буудлыг тойрон хэдэн арван зочид буудал, хэдэн зуун хоол, цэнгээний газар баригдаж, хэдэн мянган монгол залуус шинэ ажилтай болох юм.

багтаамжтай бөгөөд монголд олон жил ашиглагдсан юм.

“ Энэ онгоцны гурван зугаад захиалга Зүүн Өмнөд Азийн орнуудаас ирсэн боловч ОХУ-д барууны тавьсан хориглоос болоод нийлүүлж болохгүй байгаа учир монголд хамтарч угсрахыг санал болгосон байна. ”

Ямар ч гэсэн энэ онгоцыг, эсвэл барууны бага оврын өрсөлдөгч загварыг харьцуулан судлах, аль нэгийг нь угсрах боломжийг хайх цаг болжээ.

Монгол шиг өргөн уудам нутагтай, хот суурин бүрээ холбосон авто зам тавих нь өгөөж багатай оронд бага оврын онгоц маш их эрэлттэй. Дэлхийн улс орнууд нисдэг машин бүтээчихээд, яаж ашиглах дүрэм журмаа тогтоож байгааг бид хараад суух эрхгүй.

Өнөө маргаашийн орлогын төлөө орон сууц барих шунал хүслээс илүү олон нийт, улс оронд үр ашгаа өнө удаан өгөх Буянт-Ухаагийн буман боломжийг ухаалаг ашиглах нь эрх мэдэлтнүүдийн эрхэм үүрэг, хариуцлага мөн.





Б.Гэрэлмаа

Цогц инновацийн загвар, шийдэл мөн бизнесийн стратегийг бий болгоход түлхүү анхааран ажилладаг. АНУ-д төвтэй STEPPE TECH компанийн гүйцэтгэх захирал.

НИЙТЛЭЛ

Ноён Сун Парк
Truss Chain-ий хуулийн зөвлөх, Нью Йоркт хүлээн зөвшөөрөгдсөн хуульч



САНХҮҮГИЙН ШИНЭ ТЕХНОЛОГИЙГ АЮУЛГҮЙ НЭВТРҮҮЛЭХ БОЛОМЖ

Блокчейн тэргүүтэй тархалттай бүртгэлийн технологи нь бидний амьдарч байгаа нийгмийг хурдацтайгаар өөрчилж байгаа. Эдгээр технологид суурилсан шинэ аппликэйшний хэрэглээ, хамрах хүрээ нь тогтмол өргөжин тэлж шинэ салбаруудад эргэлт буцалтгүйгээр нэвтэрсээр байна. Хурдацтайгаар өсч, бизнесийн цоо шинэ боломжуудыг бий болгож буй энэ дэвшилтэт технологийн салбарыг зөв нутагшуулан үр ашгийг нь хүртэхийн тулд түүнд тохирсон таатай орчинг бий болгох нь зайлшгүй.

“*Хэрэв Монгол улс “ухаалаг” бодлого гаргаж, түүнийгээ хэрэгжүүлж чадвал шинэ технологид суурилсан бий болж буй хүчирхэг эдийн засаг, бизнесийг төвлөрүүлсэн төв цэг болох боломж одоо ч нээлттэй хэвээр.*”

Төрийн зүгээс энэ шинэ технологийг ямар хэмжээнд зохицуулан оролцох хэрэгтэй вэ?

ICO буюу Initial Coin Offering санхүүгийн шинэ хэрэгсэл болон гарч ирснээс хойш чухам яаж зохицуулах, ямар хууль дүрэмд захирагдах нь тодорхойгүй байв. Учир нь ICO нэг бол зөвхөн төлбөр тооцооны хэрэглээний токен эсвэл хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүнтэй (security буюу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас) дүйх шинж чанарыг агуулсан байдаг. Хэрэв тухайн токен буюу шинэ Кристо мөнгө нь security-ийн шинжийг агуулсан байвал одоо байгаа түүнд хамаарах санхүүгийн хуулиар зохицуулагдах нь зайлшгүй. Энэ нь тухайн токент хөрөнгө оруулагчдыг гарч болох залилан болон бусад санхүүгийн аюулаас хамгаалж буй хэрэг юм. Гэвч нөгөө талаараа тухайн технологийн үндсэн мөн чанарыг алдагдуулан хэт зохицуулалт хийгдсэнээс

шинэ боломжуудыг үгүй хийх талтай.

Монгол улс өгөөж нь өндөр ч, бас дутахгүй эрсдэлтэй уг шинэ дижитал технологийн салбарыг хурдан бас аюулгүй нэвтрүүлэх алтан тэнцвэрийг яаж олох вэ?

Малта нь дэлхий дээрх Кристо хамгийн ээлтэй орон гэдгээ зарлан түүнийгээ ажил хэрэг болгож буй улс. Тэд гурван хууль санаачлан баталсан бөгөөд ICO-д хянан зохицуулах агентлаг байгуулан үүнтэй хамааралтай хууль гаргасан хамгийн анхны орон болсон. Энэ нь ч үр дүнгээ өгч Кристо ертөнцийн томчууд болох Binance, OKEx, BitBay тэргүүтэй бизнесүүд салбараа нээн үйл ажиллагаагаа эрчимтэйгээр явуулж эхлээд буй.

Малта улсын баталсан гурван хууль нь Virtual Financial Assets Act (“VFA”) буюу Цахим санхүүгийн хөрөнгийн тухай акт, The Malta Digital Innovation Authority Act (“MDIA”) буюу Малтын дижитал инновацийн газрын тухай акт, мөн The Innovative Technology Arrangements and Services Act (“TAS”) буюу Дэвшилтэт технологи болон түүнд суурилсан үйлчилгээний тухай акт юм. Эдгээр хууль актуудад ICO, хөрөнгийн менежмент, crypto exchange болон түрийвч мөн хөрөнгө оруулагчдыг хамгаалах талаар дэлгэрэнгүй заасан байна.

ICO-г хөхиүлэн дэмждэг бусад орнууд нь мэдээж Сингапур, Швейцари. Тэд аль хэдийн маш өндөр түвшинд хөгжсөн хөрөнгө, санхүүгийн зах зээлтэй ба тэдгээрийг зохицуулах жишиг хууль, заалттай. Тэд блокчейн болон бусад шинэ технологийг нэвтрүүлэхдээ “Fintech Regulatory Sandbox” -г

ашигладаг. Энэ бодлогын хэрэглэгдэхүүн нь “Эдийн засагт өндөр үр нөлөө бүхий санхүүгийн дэвшилтэт технологиудыг туршин хөгжүүлэх таатай орчныг нь төрөөс бүрдүүлэн өгч, бизнесийн эрсдлийг нь багасгах мөн тухайн шинэ технологид тохирсон бодлогын загварыг шинээр бий болгох” гэсэн үндсэн зорилготой.

“ Швейцари улс Crypto Valley буюу Кристо Хөндийг цэцгэн байгуулж, санхүүгийн таатай орчин бий болгож Европын болоод дэлхийн крипто инновацийн төв болохоор ажиллаж байна. ”

Эдгээр жишээнээс харахад ICO-д хамааралтай одоо хэрэгжиж буй болон шинээр бий болох хууль, тэдгээрийн зохицуулалтыг анхнаас нь зөв чиглэлд залах төрийн агентлаг байх зайлшгүй хэрэгцээтэй болж байна. Мэдээж төрийн зүгээс мөнгө угаалтын эсрэг, терроризмын санхүүжилтийн эсрэг олон улсын хууль, тогтоомжид нийцүүлэн хамгийн аюулгүй бөгөөд ард иргэдээ олон нийтийг хамарсан крипто нэр барьсан залилангаас хамгаалах нь зүй ёсны хэрэг. Хэрэв Монгол улс ICO-ийн зөв зохицуулалтыг дээрх шалгууруудад нийцүүлэн хийж чадвал илүү бодит, чадварлаг олон улсын компаниуд монголд шинэ салбараа итгэл төгс нээн, бизнесээ өргөжүүлэх үүд хаалга бүрэн нээгдэх нь дамжиггүй.

ICO болон блокчейнийг зохицуулах тодорхой, оновчтой хуульгүйгээс олон дэвшилтэт санаанууд ажил хэрэг болж чадалгүй үлдсэн байдаг. Түүний нэг жишээ нь Black Cell Technology Limited (Black Cell) бөгөөд Хонг Конгийн security-ийн хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах боломжгүй гэсэн шалтгаанаар хаалгаа барьсан билээ.

“ Асуудлын гол нь Монгол улс бусад орны хуучинсаг чигийг даган хэт зохицуулалт хийх үү эсвэл Сингапур зэрэг орны сайн жишээг даган өөрсдийн “Sandbox”-ийг бий болгон зөв зохицуулалт хийх үү гэдэг л байгаа юм. ”

АНУ ч бас Jumpstart Our Business Startup Act-г санаачлан шинэ дэвшилтэт санаа болон бизнесүүдийг хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулахад нь төрийн зүгээс дэмжлэг үзүүлэн зарим тохиолдолд хуулиас чөлөөлөгдөх практик ч бий.

Яаж бидний өмнө гарч ирээд буй энэ шинэ боломжийг алдахгүй авч ашиглах вэ?

Одоо л бид үүнийг барьж авах цаг. 2018 оны 2-р сарын байдлаар амжилттай хэрэгжсэн 53 ICO байна. Амжилттай гэдгийг нь 10 сая ам.доллараас дээш хөрөнгө босгосон, үйл ажиллагаагаа тогтвортой явуулж буй, ямар нэгэн хууль зөрчөөгүй гэсэн үзүүлэлтүүдээр дүгнэсэн. Үйл ажиллагаа явуулж буй улсаар нь жагсаавал:

1. Сингапур: 11
2. Швейцари: 10
3. Кайманы арлууд: 7
4. АНУ: 6
5. Их Британи: 3

Сингапур, Швейцари нь чанартай ICO-ийн тоогоороо тэргүүлж байгаа нь тэдний ухаалаг бодлоготой салшгүй холбоотой. Бид ч гэсэн хурдацтай өсөн нэмэгдэж буй энэ шинэ зах зээлд оновчтой бодлого хэрэгжүүлэн оролцох боломж бүрэн нээлттэй байгаа бөгөөд давхар эдийн засгийн аюулгүй байдлаа ч хангах боломж бий. Зөв ICO-ийг сонгон жишиг болгон “Sandbox”-т шалгаруулан оруулснаар бид эдийн засаг, эрх зүйн өндөр хариуцлагатай бодлого явуулж чаддаг, блокчейн болон бусад дэвшилтэт технологийг чухлаар авч үзэн, ач холбогдлыг нь үнэлж буйгаа дэлхийд харуулна. Тэр үед олон олон бизнесүүд монголыг зорин ирэх болно.

2018 оны 8-р сар



NEW NISSAN PATROL

© 9911-0014, 9911-5140, 9910-0167

ЛИЗИНГИЙН НӨХЦӨЛ:

Урьдчилгаа **0%**

Хүү **1.4%**

Хугацаа **84 сар**

УРАМШУУЛАЛ:



Хамгаалалтын хууль


Сэлбэг орсон эрх


Аш Овлөйн дугуй


Саланы шалтай нийлвэллэг

ҮНЭ: ₮214.0 сая



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 19 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:

2018.08.05-ны дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

ҮНИЙН ХӨӨРӨГДӨЛ 7.2% БАЙНА

Инфляци гэдэг нь үнийн хөөрөгдөл юм. Жишээ нь 1990 онд хуйцаа 6 төгрөг, дундаж цалин 500 төгрөг байсан бол 2018 онд хуйцаа 12.000 төгрөг, дундаж цалин 900.000 төгрөг болсон. Үүнээс харахад яг ижил хоолны үнэ 2000 дахин өссөн байгаа бол цалин 1800 дахин өсчээ.

Монголбанкны гаргасан инфляцийн зорилтот түвшин 8 орчим хувь. Одоо хэрэглээний үнийн индексээр (ХҮИ) илэрхийлэгдсэн Улсын инфляци 7.2 хувь буюу зорилтот түвшинд нь байна. Уг нь инфляци жилийн 2 хувь байхад эдийн засаг хэвийн явж байна гэж үздэг. Гэхдээ манай улсад инфляци 8 битгий хэл уг нь 5 хүрэхгүй байвал сайн байгаа.

Хэрэглээний үнийн индекс нь инфляцийг хэмжих олон аргын нэг бөгөөд үүнд өрхийн хэрэглээний индекс, үйлдвэрлэгчийн үнийн индекс гэж байдаг. Үйлдвэрлэгчийн үнийн индексийг МУ гаргадаггүй ба харин хэрэглэгчийн үнийн индексийг ашиглан хэмждэг байна. ХҮИ нь өрхийн хэрэглээний сагсанд байгаа бараа үйлчилгээний үнийн түвшний өөрчлөлтийн жигнэсэн дунжийг гаргахыг хэлж байгаа юм. МУ энэхүү хэрэглээний сагсанд 344 бараа хийдэг ба тодорхой хугацааны давтамжаар сагсан дахь бараа өөрчлөгдөж байдаг. МУ сүүлд 2010 ба 2015 онд сагсан дахь барааг шинэчилж байсан.

Үндэсний статистикийн хороо ["Гол нэрийн барааны үнийн инфляцид үзүүлэх нөлөөлөл ба богино хугацааны инфляцийн таамаглал"](#) гэсэн судалгааны тайлан гаргасан. Манай улсад өнөөг хүртэл инфляцид нөлөөлөх хүчин зүйлсийн талаар хийгдсэн дийлэнх судалгаанууд нь инфляци ба макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн хоорондын хамаарлыг голлон судалсан байдаг. Харин энэ судалгаа инфляцийг ХҮИ-ийн бараа, үйлчилгээний нэр төрлөөр тайлбарласан. Энэ судалгааны таамаглалаар инфляци 2018 оны 6 сараас 2019 оны 2 сард бага зэрэг буурч, харин 2019 оны 3 сараас 5 сард өсөх хандлагатай.

ХҮИ-ийн сагсан дахь 344 нэр төрлийн бараа, үйлчилгээний үнээс инфляцид хамгийн их нөлөө үзүүлж буй 50 нэр төрлийн бараа, үйлчилгээний үнийг судалж тодорхойлсон байна. Эдгээр 50 нэр төрлийн бараа, үйлчилгээний ихэнх нь буюу 72 хувь нь импортын бараа. Үүнээс шоколадны кремны үнэ инфляцид хамгийн их

нөлөөлж буй бөгөөд шоколадны кремны үнийн индекс сард 10 пунктээр нэмэгдэхэд (өмнөх оны мөн үеэс) инфляцийн түвшин тухайн сард дунджаар 0.11 пунктээр өссөн (өмнөх оны мөн үеэс) гэж байна. Эдгээр 50 барааны хэдийг нь дотооддоо үйлдвэрлэдэг, хэдийг нь гаднаас авдгаас шалтгаалж валютын ханшийн нөлөө хэмжилтэд нөлөөлсөн байгаа.

Гол нэрийн барааны үнийн өөрчлөлт нь бүгд инфляцийн түвшинд эерэг нөлөөтэй байна. Инфляцийн түвшинг хамгийн их өсгөж буй гол нэрийн барааны төрөлд: Зоогийн газрын хоолны үнэ (0.01 пункт), "Боргио" пиво (0.08 пункт), цагаан тосон будаг (0.07 пункт), АИ-92 бензин (0.07 пункт), "Fairy" аяга таваг угаагч (0.07 пункт).

Мөнгөний онолоор бол мөнгөний нийлүүлэлтийг инфляци өсөх гол шалтгаан гэж үздэг. Харин мөнгөний нийлүүлэлт ЗГ-ын төсвийн алдагдлаас хамаардаг. ЗГ эдийн засгийн голлох тоглогч ба өдгөө МУ-ын ЗГ-ын худалдан авалт нийт эдийн засгийн 30-аад хувийг эзэлж байна. Зүй нь бол хөгжсөн орнуудад 17 гаруй хувь байхад л болдог ба манай улс хөгжиж байгаа орон гээд 20 гаруй хувьтай байх нөхцөлд төрийн ба хувийн өмчийн эдийн засгийн оролцоо тэнцвэртэй байх юм л даа.

Төр хяналт багатай байдаг тул маш том худалдан авалтууд хийдэг үр дүнгүйгээр гаргачихдаг. Тиймээс МУ-ын инфляцийн түвшинд төсвийн алдагдал нөлөөлж байгаа гэдгийг иргэд мэдэх ёстой. Төсвийн алдагдал байна гэдэг нь олж байгаа мөнгө нь зарж байгаагаасаа бага байгааг хэлдэг. Тэр мөнгөний зөрүү нэгэнт тэнгэрээс унаад ирэхгүй тул зээл авах эсвэл МБ-аар мөнгө хэвлүүлдэг. Төр тэр зөрүүг төлөхийн тулд нэг бол татвар нэмдэг, эсвэл мөнгө үйлдвэрлэдэг юм.

Монголбанкны гол зорилго нь үнийн тогтвортой байдлыг хангах. Гэхдээ миний бодлоор Монголбанк зорилгодоо ажлын байрны түвшинг заамаар байгаа юм. Нийт ажиллах хүчний 6 хүртэлх хувь нь ажилгүй байх юмуу аль эсвэл 5 хүртэлх хувь нь ажилгүй байхыг мөнгөний бодлогоор зохицуулдаг байх гэсэн үг. Мөнгийг бизнес рүү их нийлүүлэх тусам ажлын байр бий болгож байна гэж үздэг ба манай эдийн засгийн гол зорилгын нэг нь ажилгүйдлийн түвшин.

БОЛОВСРОЛ ЯМАР ҮНЭТЭЙ ВЭ?

Төрийн өмчийн их, дээд сургуулиуд 2018-2019 оны хичээлийн шинэ жилд сургалтын төлбөрөө 6.5-16.5 хувиар нэмнэ гэж байна. Дээд боловсролын байгууллагын сургалтын төлбөрийн асуудлыг хуулиараа Удирдах зөвлөл нь шийддэг. Улсын хэмжээнд нийт 96 их дээд сургууль байгаагийн 18 нь төрийн өмчийн сургууль. Нийт 155.000 оюутан сурдгаас бараг 90 мянга нь эдгээр 18 сургуульд суралцдаг. Эдгээр 18 сургуульд 8100 гаруй багш ажиллаж байгаа. Сургалтын төлбөрийн нэмэгдэл нь энэ олон хүний амьдралтай хамаатай асуудал учраас хариуцлагагүй хандах ёсгүй.

Одоогийн байдлаар сургалтын төлбөрөө нэмэх хүсэлт ирүүлээд байгаа сургууль:

- Монгол Улсын Боловсролын Их Сургууль: 126.000-177.000 төгрөг (хамгийн бага)
- Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль: 159.000-299.000 төгрөг
- Монгол Улсын Их Сургууль: 200.000-386.000 төгрөг
- Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль: 251.000-327.000 төгрөг (хамгийн их)

2017 оны байдлаар төрийн өмчийн их дээд сургуулиудын хичээлийн нэг кредит цагийн төлбөр нь 50-100 мянган төгрөг байна. Хамгийн өндөр нь МУИС, АШУУИС, СУИС.

МУ-ын боловсролын салбарын бодлого нь сайн биш ба МУ-ын ЗГ боловсролдамгийн хариуцлагагүй ханддаг газар мөн. Одоо төрийн өмчийн их, дээд сургуулиудад олгодог тогтмол зардлуудаа олгож чадахгүй байгаа. 2017 оны байдлаар төрийн өмчийн их, дээд сургуулиудын тогтмол зардлын 21 тэрбум төгрөгийн санал оруулахад эдийн

засгийн хүндрэлтэй байна гээд 2.1 тэрбумаар л батлагдсан гэж Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Дээд боловсролын бодлогын газрын дарга Т.Амаржаргалан хэлсэн. 21 тэрбум төгрөг гэж санал оруулаад байхад 10 дахин багасгаад өгч байна. Хагасыг нь төсвөөс, хагасыг нь төлбөрөөс ав гэсэн хэрнээ өөрсдийн хувиа олгохгүй луу унжиж байгаа төр засаг. Холимог санхүүжилтийн хэлбэр чинь бантан болгоод байгааг анхаарах хэрэгтэй. Эсвэл энэ сургуулиудыг хурдхан хувьчлах хэрэгтэй шүү дээ. Норвеги, Финлянд, Дани зэрэг орнууд дээд боловсролыг үнэгүй болгосон. Энэ нь дээд боловсролтой холбоотой тэр том зардлыг төсөв тэр чигээр нь хариуцдаг гэсэн үг.

Дээд сургуулиудыг санхүүжүүлдэг бас нэг эх үүсвэр нь хандивын сан байж болдог. Тухайн сургуулийг төгссөн хүмүүс сургуульдаа мөнгө өгдөг. Тэгснээр тухайн хүнийг татвараас чөлөөлдөг механизм хэрэгтэй байна. Энэ механизм байхгүй болохоор арилжааны банкууд, том компаниуд тэтгэлэг өгөх нэрээр реклам хийдэг. Маркетинг, хандив гэдэг чинь 2 өөр асуудал байхгүй юу. Хандив нь заавал нэр нүүрээ хэлэхгүйгээр, хариу нэхэхгүйгээр өгч байгаа мөнгө шүү дээ.

Сургалтын төлбөрийн зээл үргэлжилнэ гэж байгаа. Зээлийн нөхцлийг хөнгөвчилж, чөлөөлж өгсөн. Банкинд ямар нэгэн барьцаагүй, хүүгүй зээлийг түргэн хугацаанд олгодог боллоо гэсэн. Хорвоо дээр үнэгүй юм гэж байхгүй, харин үнэгүй юм байдаг гэж боддог хүмүүс л байгаа. Үнэгүй юм гэдэг чинь төсвөөс өгч байна аа гэсэн үг буюу та бидний татвараас л өгч байна гэсэн үг.

ВЕЙСЭЛ АКЧАЙН ХЭРЭГ ЮУ БОЛЖ БАЙНА ВЭ?

Монгол, Туркийн хамтарсан сургуулийн захирал БНТУ-ын иргэн Вейсел Акчайг (Veysel Akca) 7 дугаар сарын 27-ны өдрийн өглөө үл таних хүмүүс хулгайлсан хэрэг гараад 9 хоног өнгөрч байна.

Албан бус орчуулга

2018 оны 7 сарын 30-ны өдөр

МОНГОЛ УЛСАД ОРШИН БАЙГАА ФЕТО БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХН МЭДЭЭЛЭЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛСЫН ГАДААД ХЭРГИЙН ЯАМНЫ ХЭВЭЛЭЛИЙН ТӨЛӨӨЛӨГЧ ХАМИ АКСОЙГИЙН ӨГСӨН ХАРИУЛТ

ФЕТО террорист байгууллага нь Монгол Улсад өргөн цар хүрээг хамарсан үйл ажиллагаа явуулдаг төдийгүй Монгол улсын үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн террорист бүтэц юм. Бид уг террорист байгууллагатай холбоотой Турк Улсын болгоомжлол болон цаашид гарч болох үр дагавар, хүлээлтийг монголын талын эрх баригчидтай байнга хуваалцаар ирсэн билээ.

ФЕТО байгууллагын гишүүдийг шударга шүүхийн өмнө шүүх нь бидний хувьд зүй ёсны хүлээлт юм. Харин Монгол Улсын зүгээс уг байгууллагын эсрэг чухам ямар арга хэмжээ авах нь Монгол Улсын Засгийн газрын эрх юм. Турк Улс нь бусад улсын дотоодын аюулгүй байдлын төлөө авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд хөндөөгүй оролцдог улс биш.

Тиймээс ч өнгөрөгч Баасан гарагт Монгол Улсад болсон үйл явдлыг хүн хулгайлах үйл ажиллагаа хэмээн нэрийдэж байгаад БНТУ гүнээ харамсаж байна. БНТУ эдгээр үндэслэлгүй мэдээлүүдийг эрс няцааж байна.

Туркийн Гадаад хэргийн яам Анкара дахь Монгол Улсын Элчин сайдыг дуудаж уулзсан бөгөөд Турк Улс өөрийн байр сууриа илэрхийлж, монголын талын эрх баригчдын хандлагыг хүчтэй эсэргүүцэж байна.

Иймд, ФЕТО байгууллагын Монгол Улсад явуулж буй худал мэдээлэл түүгээх, олон нийтийг санаатайгаар төөрөгдүүлж улмаар олон нийтэд ноёлох үйл ажиллагаа нь нөхөрсөг монголын ард түмэнд аюулын харанга дэлдэж байгаа явдал хэмээн үзэж байна.


ФЕТО террорист байгууллага болон түүний Монгол дахь тархалтыг зогсоох шаардлагатай арга хэмжээг Монголын эрх баригчид авна гэдэгт найдаж байна.

Дээрх мэдэгдлээс харахад ФЕТО гэдэг байгууллага хийсэн буюу манипуляци хийж байна гэж мэдэгдсэн байна. Тэдний төр оролцоогүй, манай төр оролцоогүй юм бол хэн оролцсон бэ? МУ-д хүн хулгайлдаг бүлэг хүмүүс байгаа юм уу? Яаж тэр онгоцтой холбоотой юм бэ? Гэдэг асуултууд бүрэн тайлбар нэхэн хүлээсээр байна. Яг энэ юу болсон бэ гэдэг талаар цагдаагийн газар хэрэг нээгээд шалгаж байгаа. Үүний хариуг ард иргэдэд хурдан мэдээлэхийг цагдаагийн газраас иргэд шаардах ёстой.

МУ-ын Гадаад Харилцааны Сайд Д.Цогтбаатар Монгол Улсаас БНТУ-д суугаа Элчин сайд Р.Болдыг эх орондоо дуудсан гэж байгаа. Гэхдээ элчин сайд ирж уулзаад яана гэж?

Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв.

Тоймын бүрэн эхийг www.jargaldefacto.com вебсайтаас үзэх боломжтой



JARGAL DEFACTO

ГАР УТАСНЫ АППЛИКЭЙШН

The Defacto Gazette

➤ АНГЛИ

➤ МОНГОЛ

➤ ЯПОН



Та “Дефакто Газет” цахим сонинг төлбөргүй тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
 Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
 Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
 Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com

✉ +976 94109342

🌐 www.defacto.mn